



ЕБС-ИЙН АНГЛИ ХЭЛНИЙ БАГШ НАРЫН ХЭРЭГЦЭЭНД ТУЛГУУРЛАСАН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН АГУУЛГА

Бм.Болормаа
МУБИС-ийн НХУС-ийн Англи-герман хэл, аргазүйн тэнхмийн багш
Д.Оргилмаа
Сантис Боловсролын төвийн ерөнхий захирал
Ц.Үрэлмаа
CELPA, TOEIC ШМҮТ захирал, доктор

Abstract: This paper discusses the curriculum content and current trends in continuing professional development for English language teachers (n≈580) in secondary schools in 2014 at the Institute of Teacher's Professional Development. The needs analysis (n=814) conducted in 2013 revealed that the majority of teachers (n=413) was eager to improve both the self-competence and professional competence in in-service teacher training programs. After administering TOEIC (Test of English for International Communication) (n=500), test takers' mean TOEIC listening comprehension score was 188 out of 495 and mean TOEIC reading comprehension score was 143 out of 495. In other words, mean total TOEIC score of secondary school teachers was 331 out of 990. Based on the needs analysis in 2013 and TOEIC scores in 2014, the 24-hour-lecture and 24-hour-workshop were conducted by native English teachers. It focused on developing teachers' knowledge of three key areas – standard, methodology and English language skills. Teachers were also encouraged to actively reflect on their own prior learning and teaching experience.

Түлхүүр үг: хөтөлбөрийн агуулга, стандарт, хувийн чадамж, мэргэжлийн хөгжил, заах аргазүй

МУБИС нь улсын хэмжээнд англи хэлний багшлах боловсон хүчнийг голлон

бэлтгэдэг сургуулийн хувьд ЕБС-ийн англи хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг жил бүр тогтмол явуулж ирсэн ба цаашид зохиох сургалтын агуулгыг улам бүр шинэчлэн сайжруулах, чанаржуулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх үүднээс дотоод нөөц бололцоогоо ашиглахаас гадна ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй дотоод, гадаадын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, туршлага солилцох үүднээс БМДИ-ээс зохион байгуулсан сургалтын хөтөлбөрийн агуулгыг танилцуулав.


Энэхүү сургалтыг зохион байгуулахын өмнөх бэлтгэл шатанд БСШУЯ-ны БМДИ, Англи хэлний хөтөлбөрийг магадлан итгэмжлэх холбоо (CELPA) хамтран ЕБС-ийн англи хэлний багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хэрэгцээг тодруулах зорилгоор 18 аймаг, нийслэлийн ЕБС-ийн нийт 814 англи хэлний багшаас өөрийн үнэлгээний судалгааг 2013 онд асуулга ба тодруулах ярилцлагын аргаар хийж гүйцэтгэв. Уг судалгааны багт БМДИ, CELPA, МУБИС болон МУИС-ийн судлаач багш нар орж ажиллав.

Англи хэлний багш нарын мэдлэг ур чадварын түвшинг өөрийн үнэлгээгээр нь тодорхойлох зорилготой асуулгад багш нарын 70 гаруй хувь нь өөрсдийгөө сайн болон маш сайн гэж үнэлсэн ба харин нийт багшийн 3 хувь нь өөрийгөө дундаас доогуур

түвшин байна гэж үнэлсэн байна.

Бүдүүвч 1


Багш нар англи хэлний ур чадвараа үнэлсэн нь



Гэхдээ энэхүү англи хэлний ур чадварын үнэлгээг дотор нь ярих, сонсох, унших, бичих чадвараар задлан авч үзвэл харьцангуй үр дүн гарсныг Бүдүүвч 2-т үзүүлэв.

Бүдүүвч 2

Багш нарын 4 ур чадварын индексийн дундаж (өндөр байх тусам сайн)



Үүнээс үзэхэд багш нар өөрийн бичих, унших чадвараа ярих, сонсох чадвараас дээгүүр гэж үнэлсэн байна.

Мөн судалгааны дүнд дийлэнх багш нар (n=413) англи хэлний чадварыг дээшлүүлэх ба англи хэл заах аргагүй хосолсон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахыг хүсчээ. Улмаар энэхүү хэрэгцээний судалгаан дээр үндэслэн БМДИ-ээс ЕБС-д тав, зургаа, арав, арван нэгдэх жилдээ ажиллаж буй англи хэлний 580 гаруй багшид зориулсан үндсэн сургалт зохион байгуулах зөвлөх үйлчилгээний тендерийг зарласан ба Сантис Боловсролын Төв (СБТ) түүнд шалгарч, сургалтыг 5 ээлжээр 2014 оны 5-8-р сард зохион байгуулав.

Түүнчлэн БМДИ-ийн хүсэлтээр мэргэжил дээшлүүлэхээр ирсэн эдгээр 580 багшаас 500-г нь TOEIC Шалгалт, мэдээллийн үндэсний төв (ШМУТ)-ийн TOEIC олон улсын шалгалтад 2014 оны 5-8-р сард хамруулав. АНУ-ын ETS төвөөс боловсруулан гаргадаг TOEIC шалгалт нь англи хэлийг гадаад хэлний хувьд сурч буй хүмүүсийн ажлын байранд шаардагдах ангиар харилцах өдөр тутмын хэрэглээний чадварыг олон улсын түвшинд тогтоодог англи хэлний сонсох, унших чадварын шалгалт юм. Шалгалт нь өдөр тутмын үйл ажиллагааны англи хэлний хэрэглээнээс өөр бусад нарийн мэргэжлийн үг хэллэг, үгийн нөөц шаарддаггүй.

Одоогоор TOEIC шалгалтыг дэлхийн 150 гаруй орны нийгмийн дийлэнх салбарын 14000 гаруй байгууллага бүхий л шатандаа, тухайлбал, сургуулиудын элсэлт, төгсөлтийн шалгалт, байгууллагууд шинээр боловсон хүчин шалгаруулж авах, албан тушаалд дэвшүүлэн томилох, зэрэг дэв ахиулах зэрэг өөрсдийн үйл ажиллагаандаа англи хэлний мэдлэгийн



түвшин тогтоох нэгэн шалгуур болгон ашиглаж байна. Институцийн TOEIC шалгалт нь сонсох, унших гэсэн хоёр төрлийн хэсгээс бүрдэх бөгөөд шалгуулагчдын чадварыг тус тусад нь дүгнэж гаргадаг. Үүнд сонсох, унших шалгалтын хамгийн дээд оноо тус бүр 495, нийтдээ 990 гэсэн оноогоор дүгнэгддэг.

Шалгалтын онооноос хамаарч шалгалтын гэрчилгээний хүрээ нь алтадмал, хөх, ногоон, бор, улбар шар гэсэн 5 төрлийн өнгөтэй байдаг.

Хүснэгт 1

TOEIC шалгалтын онооны шатлал

Дээд оноо	860-990		Gold
	730-855		Blue
	470-725		Green
	220-465		Brown
Доод оноо	10-215		Orange

TOEIC онооны шатлалыг бусад англи хэлний олон улсын шалгалтын оноотой Хүснэгт 2-т харьцуулан авч үзэв.


Хүснэгт 2

TOEIC	TOEFL Paper	TOEFL CBT	TOEFL IBT	IELTS	Cambridge Exam	CEFR
0 - 250	0 - 310	0 - 30	0 - 8	0 - 1.0		
	310 - 343	33 - 60	9 - 18	1.0 - 1.5		A1
255 - 400	347 - 393	63 - 90	19 - 29	2.0 - 2.5		A1
	397 - 433	93 - 120	30 - 40	3.0 - 3.5	KET (IELTS 3.0)	A2
					PET (IELTS 3.5)	B1 (IELTS 3.5)
405 - 600	437 - 473	123 - 150	41 - 52	4.0	PET	B1
	477 - 510	153 - 180	53 - 64	4.5 - 5.0	PET (IELTS 4.5)	B1 (IELTS 4.5)
					FCE (IELTS 5.0)	B2 (IELTS 5.0)
605 - 780	513 - 547	183 - 210	65 - 78	5.5 - 6.0	FCE	B2
	550 - 587	213 - 240	79 - 95	6.5 - 7.0	CAE	C1
785 - 990	590 - 677	243 - 300	96 - 120	7.5 - 9.0	CPE	C2
Top Score	Top Level					
990	677	300	120	9	100	C2

БМДИ-ийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан нийслэл ба орон нутгийн ЕБС-ийн англи хэлний 500 багшийн TOEIC-ийн дундаж оноог дараах хүснэгтээр нэгтгэн харуулав.

Хүснэгт 3


Нийт шалгуулагчийн TOEIC-ийн дундаж оноо



Бүдүүвч 3

TOEIC шалгалтын дундаж оноо

Нийт онооны дундаж




Энэ нь манай багш нарын дийлэнх болох 75 хувь нь 3-р түвшин буюу анхан дунд шатны хязгаарлагдмал чадвартай хэмээн дүгнэгджээ. Оноонд дүйцүүлэх чадамж нь: *Ойлгох чадвар сайн ч харилцан ярианд чөлөөтэй оролцохдоо өгүүлбэрийн болон дүрмийн бүтэц дээр алдаа гаргадаг тул ажлын байранд мэргэжлийн түвшинд хязгаарлагдмал чадамжтай* хэмээн тодорхойлогдоно.

Улмаар шалгуулагчдын сонсож ба уншиж ойлгох дундаж оноог TOEIC-н дээд оноотой дараах бүдүүвчид харьцуулав.

Бүдүүвч 4

Шалгуулагчдын сонсох ба унших чадварын дундаж



Дээрх мэдээ баримтаас үзэхэд шалгалтад хамрагдсан англи хэлний багш нарын сонсох чадвар өнөөгийн бодит байдлаар 188 оноо буюу 37%, унших чадвар 143 оноо буюу 28%- тай байгаа нь Бүдүүвч 1, 2-т үзүүлсэн өөрийн үнэлгээнээс ихэд зөрүүтэй байв. Шалгуулагчдын нийт онооны дунджаас үзэхэд тэдгээрийн 75% нь 220-465 оноо авсан байгаа нь ЕБС-ийн англи хэлний багш нарын ерөнхий мэдлэг чадвар, мэргэжлийн ур чадварыг сайжруулах асуудал англи хэлний боловсролын тулгамдаж буй асуудлын нэг болж буйг харуулж байна.

Иймд БШУЯ-ны Сайдын 2013 оны 8-р сарын 9-ний өдрийн А/287 тоот тушаалаар баталсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ыг баримталж, ELTeach- Англи хэл заах аргазүйн олон улсын хөтөлбөрийг үндэслэн боловсруулсан сургалтыг төлөвлөж зохион байгуулсан байна. Уг журамд “... багш нарт туршлагаа хуваалцах, харилцан суралцах, дидактикийн онол арга зүй эзэмшүүлэх” гэж тусгасны дагуу сургалтыг лекц, семинар хэлбэрээр онол, практик хослуулан зохион байгуулжээ.

ЕБС-ийн нийт 580 гаруй англи хэлний багш хамрагдсан сургалтыг 5 ээлжээр зохион байгуулж, англи хэлний боловсролын өнөөгийн чиг хандлага, олон улсын стандарт, англи хэл заах арга зүйн сүүлийн үеийн арга техникүүдийн чиглэлээр нийт 24 цагийн лекц сонгож, 24 цагийн дадлага ажил, семинар хийлгэсэн байна.

Өнөө үеийн англи хэлний боловсролын эрэлт, хэрэгцээг хангасан сургалт зохион байгуулахын тулд англи хэлний заах арга зүйн чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн багийг бүрдүүлсэн ба сургалтыг зөвхөн англи хэл дээр явуулав. АНУ, Их Британи, Канад, Австрали улсын төрөлх англи хэлтэй мэргэжлийн сургагч багш нарын баг хичээл заасан нь энэ удаагийн сургалтын онцлог давуу тал байв. Гадаадын олон оронд англи хэл заах арга зүйн сургагч багшаар ажиллаж, гадаад оюутанд англи хэл заах олон жилийн туршлага хуримтлуулсан сургагч багш нар



болох Англи улсын иргэн Дэвид Жасмин, АНУ-ын иргэн Дайан Янг, Австрали улсын иргэн Стюарт Онанс нар уг багт ажилласан байна.

Сургалтын хөтөлбөр

Сургалтын хөтөлбөрийн агуулга нь ELTeach- англи хэл заах арга зүйн олон улсын чиг хандлага, хөтөлбөрийн агуулгын хүрээнд *стандарт, хэлний чадвар, заах арга зүй* гэсэн 3 чиглэлд хуваагдсан бүтэцтэй байлаа. Сургалтын агуулга, хөтөлбөрийг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй үзүүлэв.

Teacher Training Essentials for Professional Development

Target Audience: In Service / Experienced English Language teachers in Mongolia

Aim: The training develops teachers’ knowledge of three key areas; methodology and language. They also encourage teachers to actively reflect on their own prior to learning and teaching experience.

VERSION 1:LECTURE (FOLLOWED BY WORKSHOP)

Хүснэгт 4

Day 1 Session 1: Current Global Development in English Language Teaching and Global Standards

Context / Topic	Content	Main Learning Outcomes	Hours
1. New conception in English Language Teaching	English -for- teaching English Language teaching as they learn usable English to conduct a lesson and build confidence in language use in the classroom.	Teacher will learn more about the ELTeach Global Pilot countries and how participating teachers improved their overall confidence teaching English in English.	2
2.Global Assessment of English Language Proficiency	*The use of English Language in the Globalized World *The Case for a comprehensive Assessment of English Language Proficiency.	To raise awareness of Global Assessment of English Language and prepare the students to compete in the competitive global workforce.	2
3. Technology Standards for Language Teachers	4 overarching goals and a total of 14 standards.Each standard includes performance indicators and at least one vignette.	Language Teachers acquire and maintain foundational knowledge and skills in technology for professional purposes and integrate pedagogical knowledge and skills with technology to enhance language teaching and use it	2
4. TESOL P-12 Professional Teaching Standards	Standards at-a glance TESOL P-12 Professional Teaching Standard Domain-Language, Culture, Instruction, Assessment and Professionalism	Will be introduced Diverse users of the TESOL P-12 Professional Teaching Standards and offered also recommendations for implementing the Standards in varied contexts and for a range of purpose.	2

Хүснэгт 5

Day 2 Session 2: Language Development

Context / Topic	Content	Main Learning Outcomes	Hours
5. Teaching tips for Reading and Listening Skills	*Topic development * Reading and Listening Skills * Key Language * Main Task Type	Teacher will learn about concepts such as organizing the four skills in the classroom and using feedback to support learning.	4
6. Teaching tips for speaking and writing Skills	*Topic development * Speaking and Writing Skills * Key Language * Main Task Type		4

Хүснэгт 6

Day 3 Session 3: Classroom Methodology

Context /Topic	Content	Main Learning Outcomes	Hours
7. Classroom Management and teacher Language	* Interaction patterns * Teacher Language * Giving Instruction * Managing the learner group	To explore effective ways of setting and managing classroom activities.	2
8. Lesson Planning	* Different Jobs-different plans * Some pointers about planning * Some teachers' view * Getting it in the right order	To outline the contents of a formal lesson plan and raise awareness about appropriate lesson aims.	2
9. Exploiting authentic materials	* Choosing some material * Good task, bad task * The pros and cons	To explore the process of using authentic materials in the classroom.	2
10. Functional Language	* Language style and politeness * Indirect requests * Varying forms of functional exponents * Evaluation of teaching materials	To introduce and explore the nature of functional language	2
Total hours			24

Лекцээр олж авсан онолын мэдлэгийг практик дадлагаар баталгаажуулах зорилгоор сургалтын ихэнх цагийг семинар дадлага ажил, хэлэлцүүлэг хэлбэрээр зохион байгуулснаар суралцагчид өөр хоорондоо туршлага солилцох, унаган англи хэлтэн багш нартай санал бодлоо хуваалцаж, чөлөөтэй ярилцах, сурах орчин бүрдүүлсэнд сургалтын үр дүн, ач холбогдол оршиж байв.

Teacher Training Essentials for Professional Development

Target Audience: In Service / Experienced English Language teachers in Mongolia

Aim: The training develops teachers' knowledge and teaching skills in the classroom which teachers had acquired through the previous lectures.

VERSION 2: WORKSHOP FOR PROFESSIONAL DEVELOPMENT (4 Groups, 30 teachers each group)



Хүснэгт 7

Day 4 Session 4: Global Technology Standards

Context / Topic	Content	Main Learning Outcomes	Hours
11. Technology Standards for Language Teachers	Goal 1: Standard 1; Standard 2; Standard 3 Goal 2: Standard 3	Help teachers and teachers educators better understand the technology standards and how they can be applied in the varied contexts in which language instruction occurs.	4
12. TESOL P-12 Professional Teaching Standards	Standards at-a glance TESOL P-12 Professional Teaching Standard Domain-Language, Culture, Instruction, Assessment and Professionalism	Will be introduced Diverse users of the TESOL P-12 Professional Teaching Standards and offered also recommendations for implementing the Standards in varied contexts and for a range of purpose.	4

Хүснэгт 8

Day 5 Session 5: Language Development

Context / Topic	Content	Main Learning Outcomes	Hours
13. Teaching tips for Reading and Listening Skills	* Teaching receptive skills: Reading & Listening * Reading sub skills * The differences between listening and reading * Managing the challenge of listening	To raise awareness of successful planning and managing of receptive skills lessons	4
14. Teaching tips for Reading and Listening Skills	* Oral fluency and speaking skills * Good ideas for oral fluency tasks * Spoken and written language * Some questions about writing	To explore ways of planning and managing activities that develops learners' oral fluency and speaking skills.	4

Хүснэгт 9

Day 6 Session 6: Classroom Methodology

Context / Topic	Content	Main Learning Outcomes	Hours
15. Classroom Management and teacher Language	* Interaction patterns * Teacher Language * Giving Instruction * Managing the learner group	To explore effective ways of setting up and managing a range of classroom	2
16. Lesson Planning	* Different Jobs-different plans * Some pointers about planning * Some teachers' view * Getting it in the right order	To outline the contents of a formal lesson plan and indicate ways of working lesson aims.	2
17. Exploiting authentic materials	* Choosing some material * Good task, bad task * The pros and cons	To demonstrate processes for creating tasks and activities that can be used for exploiting authentic materials with learners.	2
18. Functional Language and assessing young learners	* Language style and politeness * Indirect requests * Varying forms of functional exponents * Evaluation of teaching materials	To clarify the nature of functional language and exemplify commonly taught functional exponents.	2
Total hours			24

ДҮГНЭЛТ

Дэлхий дахинаа багшийн чадамжийг (teacher competence) хувийн (self-competence), мэргэжлийн (professional competence), нийгэмшлийн (social competence) гэж гурав ангилсныг TOEIC шалгалтын дүнтэй харьцуулан дүгнэхэд ЕБС-ийн англи хэлний багш нарын анхан шатны буюу хувийн чадамжийг нэн тэргүүнд хөгжүүлэх шаардлагатай байгаа нь тогтоогдлоо.

Дэлхийн боловсролын даяаршлын энэ зуунд манай орны боловсролын шинэчлэлийн гол хүч болсон багш нарын мэргэжлийн бэлтгэл, заах арга зүйн ур чадвар, мэдлэг боловсролыг зах зээлийн нийгмийн хэрэгцээ шаардлага, олон улсын стандартад нийцүүлэн сайжруулах шаардлагатай тулгарч байна.

Эдгээрийг хэрэгжүүлэх зорилгоор БМДИ-ийн захиалгын дагуу энэхүү ЕБС-ийн англи хэлний 580 орчим багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулжээ. Боловсролын шинэчлэлийн нэгэн цөм болсон сургалтын хөтөлбөрийн агуулга нь манай улсын англи хэлний багш нарын мэргэжлийн ба хувийн чадамжийг сайжруулахад голлон чиглэсэн байна. Улмаар англи хэл заах арга зүйн олон улсын чиг хандлага, хөтөлбөрийн агуулгын хүрээнд стандарт, хэлний чадвар, заах арга зүй гэсэн гурван чиглэлээр төрөлх англи хэлтэй сургагч багш нарын боловсруулсан хөтөлбөрийн дагуу энэхүү сургалт амжилттай явагдсан байна.

Санал, зөвлөмж

Нэг. Хэл бол харилцааны хэрэглүүр тул англи хэлний багшийн мэргэжлийн онцлог нь гадаад хэлний байнгын хэрэглээ шаарддаг учир багш нарын мэдлэг чадварыг оновчтой, үр дүнтэй олон хэлбэрээр байнга тасралтгүй дээшлүүлэх;

Хоёр. Англи хэлний багшийн мэдлэг чадварыг олон улсын стандартаар тогтоох тодорхой журам боловсруулж, багш бүрт мэдлэг чадвараа бодитойгоор үнэлүүлж ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

Гурав. Англи хэлийг гадаад хэл болгон судалж буй орнуудын туршлагыг судлан Монгол улсын ЕБС-ийн англи хэлний багш нарын мэдлэг чадварын “бенчмарк” тогтоож, тэдний мэдлэг чадварыг үе шаттайгаар жигд сайжруулах;

Дөрөв. ЕБС-ийн англи хэлний багш нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх төсөл, хөтөлбөр боловсруулан, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дотоод, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах. Тухайлбал, ETS төвд хандаж тусламж дэмжлэг авах боломжийг судлах;

Тав. Хэлний дадлага хийлгэх. Гадаад хэлний багш нарыг төрөлх англи хэлтэй оронд хэлний дадлага хийлгэх боломжийг судлах.

Эдгээр арга хэмжээг авснаар ЕБС-ийн англи хэлний багш нарын мэдлэг чадвар дээшилж, Монгол улсын боловсролын тогтолцооны шинэ чиг хандлагыг тодорхойлоход ихээхэн ач холбогдолтой болно хэмээн үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Мөнхжаргал, Д. (2013). Багш боловсролын шинэчлэл. *Гадаад хэл заах арга зүйн асуудал*, 35,4-7

МУ-ын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/136-р тушаал “Багшийн хөгжил хөтөлбөр”-ийн 4.1.1, 4.1.4

МУ-ын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/287-р тушаал. “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ын 2.3, 2.7

Thaine, G. (2010). *Teacher training essentials*. Cambridge University Press.

TOEFL Equivalency Table. Vancouver English Centre. Retrieved on September 14, 2015 from <https://secure.vec.bc.ca/toefl-equivalency-table.cfm>